



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/449

Улаанбаатар хот

Эрэгтэйчүүдийн кабинетын үлгэрчилсэн  
загвар, ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.7 дахь заалт, Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-ний 1.3 дахь үйл ажиллагааг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрэгтэйчүүдийн кабинетын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар, ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц”-ыг хоёрдугаар “Эрэгтэйчүүдийн кабинетэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Байгууллагын батлагдсан төсөвт багтаан эрэгтэйчүүдийн кабинетын эмч, мэргэжилтнийг бэлтгэн, нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангаж, тасаг кабинет нээн ажиллуулахыг өмчийн бүх хэлбэрийн лавлагаа шатлалын амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/, Санхүү, эдийн засгийн газар /Б.Мөнхтуул/, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Урологи-Андрологийн төв /Д.Баян-Өндөр/, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж бэлтгэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбоотой Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 293 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222205

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09  
дугаар сарын 01-ны өдрийн 119 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



## ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН КАБИНЕТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР, АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Зорилго нь эрэгтэйчүүдийн кабинетын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, эмч, мэргэжилтнүүдийн эрх, үүргийг тодорхойлоход оршино.
- 1.2 Эрүүл мэндийн байгууллага энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ урологийн кабинетаар үйлчлүүлэх эмэгтэй үйлчлүүлэгч, өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлэх өсвөр насны эрэгтэй хүүхдийн үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг алдагдуулахгүй байхаар зохион байгуулна.
- 1.3 Эрэгтэйчүүдийн кабинетын үйлчлэх хүрээ нь биологийн болон жөндөрийн хүйсийн хувьд бүх насны эрэгтэй хүний өвөрмөц хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ байна.
- 1.4 Кабинетын үйлчилгээ нь Монгол эрэгтэйчүүдийн насны бүлэг, ажлын байрны онцлог, амьдралын хэв маягт тохирсон зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, “Эрт илрүүлэг” үзлэгт хамруулах, эрүүл мэндийг хамгаалах ажлыг дэмжих үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн нэгжтэй хамтран зохион байгуулж ажиллана.
- 1.5 Эрэгтэйчүүдийн кабинет нь энэхүү дүрэм болон Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

### Хоёрдугаар бүлэг. Нэр томъёоны тайлбар

- 2.1 Эрэгтэйчүүдийн кабинетын эмч гэж Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их, дээд сургууль төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтаар урологи болон андрологийн нарийн мэргэшил эзэмшсэн эмчийг хэлнэ.
- 2.2 Эрэгтэйчүүдийн кабинетын сувилагч гэж Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй мэргэжилтнийг хэлнэ.
- 2.3 Эрэгтэйчүүдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэж нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг эрэгтэйчүүдэд зориулсан чанартай, чирэгдэлгүй, тохиромжтой, хүртээмжтэй, нууцлалыг хангасан эрүүл мэндийн цогц байдлыг хэлнэ.

### Гуравдугаар бүлэг. Үндсэн зарчим

- 3.1 Эрэгтэйчүүдийн бөөр шээсний замын болон нөхөн үржихүйн эрхтэний эмгэгийн оношилгоо, эмчилгээ үзүүлэх чадамжтай байх

- 3.2 Эрэгтэйчүүдийн хэрэгцээнд тохирсон ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байх
- 3.3 Хувь хүний эрүүл мэндийн нууцлалыг хадгалдаг байх
- 3.4 Холбогдох тусламж, үйлчилгээний заавар, стандартыг мөрдлөг болгон ажилладаг байх

#### **Дөрөвдүгээр бүлэг. Зохион байгуулалт**

- 4.1 Эрэгтэйчүүдийн кабинет нь өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн тусламж, үйлчилгээний бүтцийн нэгж байна.
- 4.2 Эрэгтэйчүүдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээнд зориулсан чанартай, чирэгдэлгүй, хүртээмжтэй, нууцлалыг хангасан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн мэргэшсэн цогц тусламж, үйлчилгээ байна.
- 4.3 Кабинет нь эрэгтэйчүүдийн бөөр шээсний замын эмгэг болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 4.4 Эрэгтэйчүүдийн кабинетын эмч, сувилагчийг нийгмийн эрүүл мэндийн сургалтад тасралтгүй хамруулах ажлыг тогтмол зохион байгуулна.
- 4.5 Эрүүл мэндийн байгууллага эрэгтэйчүүдийн кабинетын үйл ажиллагаанд бодлого, удирдлага, санхүүгийн дэмжлэг үзүүлэн урологи-андрологийн эмчийг мэргэшүүлэх сургалтад хамруулна.

#### **Тавдугаар бүлэг. Ерөнхий шаардлага**

- 5.1 Кабинет нь эмч, сувилагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.
- 5.2 Кабинетын эмч, сувилагч нь зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах, осол гэмтлээс сэргийлэх зөвлөгөө өгөх, эрт илрүүлгийн сургалтад хамрагдсан байна.
- 5.3 Кабинет нь эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээнд тохирсон, чанартай, үр дүнтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, тавилга, компьютер, интернет, ном тохимол болон бусад хэрэгцээт зүйлээр бүрэн хангагдсан байна.
- 5.4 Кабинет нь үзлэгийн өрөө, ажилбарын өрөөтэй байна.
- 5.5 Кабинет нь өөрийн хүрээний эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар мэдээллийн сан үүсгэсэн байна. Мэдээллийн сан хувь хүний нууцлалыг хуулийн хүрээнд хамгаалсан байна.
- 5.6 Кабинет нь өөрийн үйлчлэх хүрээний эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээний байдалд тогтмол үнэлгээ, судалгаа хийж шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй зохион байгуулна.
- 5.7 Кабинет нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чамд баримтлан ажиллана.

## **Зургаа дугаар бүлэг. Үйл ажиллагааны чиглэл**

- 6.1 Эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээнд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмчлэн эрүүлжүүлэх, зөвлөгөө өгөх
- 6.2 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар лавлах мэдээллийн багц бэлтгэн, өсвөр үеийнхэн болон тэдний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулах
- 6.3 Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн асуудлаар боловсрол нийгмийн хамгааллын болон бусад салбартай хамтран ажиллаж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах
- 6.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, ЕБС, МСҮТ, их дээд сургууль, коллежийн эмч, эрэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
- 6.5 Кабинетын үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргах
- 6.6 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр тулгамдаж байгаа асуудлын талаар судалгаа хийн, сургалт явуулах

## **Долоо дугаар бүлэг. Кабинетын ажиллах бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь**

- 7.1 Эмч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
  - 7.1.1 Кабинетын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах
  - 7.1.2 Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
  - 7.1.3 Үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэх, хамтран ажиллах
  - 7.1.4 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар хамтран ажиллах
  - 7.1.5 Урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурталчилгаа зохион байгуулах
  - 7.1.6 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулах
  - 7.1.7 Эрэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ бусад үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах
- 7.2 Сувилагч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
  - 7.2.1 Үйлчлүүлэгчийн карт нээх, хөтлөх
  - 7.2.2 Кабинетын үйл ажиллагааны талаарх мэдээллийг холбогдох газарт мэдээлэх
  - 7.2.3 Эрэгтэйчүүдэд мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах
  - 7.2.4 Үйлчлэх хүрээний эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, баяжилт хийх

Эрүүл мэндийн сайдын 2022 оны ...<sup>09</sup>  
дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

## ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ

### НЭГ. Эрэгтэйчүүдийн кабинет

#### Зорилт:

1. Эрэгтэйчүүдийн кабинетын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлдэг байна.
2. Эрүүл мэндийн ажилтнууд эрэгтэйчүүдийн кабинетаар үйлчлүүлсэн иргэдийн нууцыг хадгална.
3. Эрэгтэйчүүдийн кабинетын эмч, сувилагч эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хөгжлийн асуудлаар сургалтад тогтмол хамрагдаж байна.

#### Үйлчилгээ үзүүлэгчид:

1. Тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн лавлагаа шатлалын амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын эрэгтэйчүүдийн кабинетын эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд

#### Тусламж, үйлчилгээний багц:

1. Эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээ шаардлагад нийцсэн үзлэг, шинжилгээг хийх
2. Эрэгтэйчүүдийн амбулаторийн үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх
3. Эрэгтэйчүүдийн урологи, андрологийн чиглэлээр өдрийн эмчилгээ болон амбулаториор хийгдэх мэс ажилбаруудыг хийх
4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар сэтгэлзүйн зөвлөгөө өгөх
5. Төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах
6. Эрэгтэйчүүдийн өсөлт хөгжил, бие бялдрын хөгжилд үнэлэлт, дүгнэлт хийх
7. Шаардлагатай тохиолдолд дээд шатлалын үйлчилгээнд шилжүүлэх
8. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох албан бус сургалтыг зохион байгуулах
9. Харьяа нутаг дэвсгэрийн ЕБС, МСҮТ, их дээд сургууль, коллежийн удирдлага, эмч нартай нягт хамтран ажиллаж, оюутан сурагчдын эрүүл мэндийг дэмжиж ажиллах
10. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа явуулж орон нутгийн засаг захиргаа, удирдлагаас дэмжлэг авах

**НЭГ. Кабинетын өрөө тасалгааны тоо, хэмжээ**

№	Өрөө, тасалгааны нэр	Талбайн хэмжээ	Өрөөний тоо
1.	Үзлэгийн өрөө /Эмчийн өрөө/	12-18 м.кв	1
2.	Боолтын өрөө /Ажилбарын/	22 м.кв дээш	1 (бохир, цэвэр)

**ХОЁР. Эрэгтэйчүүдийн кабинетад хийх мэс ажилбар, гардан үйлдлүүд**

№	Үйлдлийн нэр	Хэн гүйцэтгэх	Туслах
1.	Шээдэг сүвээр гуурс тавих	Их эмч, сувилагч	Сувилагч, резидент
2.	Төмсөг сойх (боолт)	Их эмч, сувилагч	Сувилагч, резидент
3.	Шээдэг сүвний зураг авах	Их эмч	Мэс заслын сувилагч
4.	Шамранз арьсанд зүслэг хийх	Их эмч	Мэс заслын сувилагч
5.	Умранз арьс авах мэс засал	Их эмч	Мэс заслын сувилагч
6.	Шодойноос эдийн шинжилгээ авах	Их эмч	Сувилагч
7.	Давсагт цистостом гуурс тавих	Их эмч	Сувилагч
8.	Бөөрөнд нефростом гуурс тавих	Их эмч	Сувилагч
9.	Түрүү булчирхайд массаж хийх	Их эмч	Сувилагч
10.	Төмсөг болон түрүү булчирхайнаас эдийн шинжилгээ авах	Их эмч	Сувилагч
11.	Шодойн хөндийлөг биед хатгалт хийж цус авах	Их эмч	Сувилагч

**ГУРАВ. Эрэгтэйчүүдийн тусгайлсан үнэлгээ хийх хуудас**

**1. Шодойн хөвчрөлтийн олон улсын үнэлгээ (International Index Erectile function)**

№	Асуумж	Үнэлгээ /1-5 хүртэлх оноогоор/				
		Маш муу /1 оноо/	Муу /2 оноо/	Дунд зэрэг /3 оноо/	Сайн /4 оноо/	Маш сайн /5 оноо/
1.	Та өөрийн шодойн хөвчрөлтийг хэр зэрэг гэж үнэлэх вэ?					
2.	Шодой хангалттай хатуурч хөвчрөх нь хир зэрэг олон бэ?	Бараг үгүй /1 оноо/	Талаас бага хувьд /2 оноо/	Тал хувьд нь /3 оноо/	Ихэнх хувьд нь /4 оноо/	Тогтмол /5 оноо/

3.	Хурьцлын үед шодойг үтрээнд хөвчирсэн байдалд удаан байлгаж чаддаг уу?	Бараг үгүй /1 оноо/	Талаас бага хувьд /2 оноо/	Тал хувьд нь /3 оноо/	Ихэнх хувьд нь /4 оноо/	Тогтмол /5 оноо/
4.	Шодойг хөвчирсэн байдалд барих нь хэр хүнд асуудал вэ?	Маш хүнд /1 оноо/	Хүнд /2 оноо/	Хүндхэн /3 оноо/	Бага зэрэг хүнд /4 оноо/	Хүнд биш /5 оноо/
5.	Хурьцлын дараа сэтгэл ханамжтай байдаг уу?	Бараг үгүй /1 оноо/	Талаас бага хувьд /2 оноо/	Тал хувьд нь /3 оноо/	Ихэнх хувьд нь /4 оноо/	Тогтмол /5 оноо/

❖ Үнэлгээний тайлбар:

- 22-25 оноогоор үнэлсэн бол хэвийн шодой хөвчрөл
- 17-21 оноогоор үнэлсэн бол хөнгөн хэлбэрийн шодой хөвчрөл
- 12-16 оноогоор үнэлсэн бол хөнгөнөөс дунд зэргийн шодой хөвчрөл
- 8-11 оноогоор үнэлсэн бол дунд зэргийн шодой хөвчрөлтэй гэж тус тус үнэлнэ.

2. Түүрүү булчирхайн шинж тэмдгийн олон улсын үнэлгээ (International Prostate Symptom Score)

№	Сүүлийн нэг сарын турш	Үгүй	Хааяа	Талаас бага хувьд нь	Тал хувьд нь	Талаас илүү хувьд нь	Ихэвчлэн
1.	<b>Давсаг суллах:</b> Шээсний дараа дутуу шээсэн мэт санагддаг уу?		/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/
2.	<b>Давтамж:</b> Шээсний дараа 2 цаг хүрэлгүй дахин шээдэг үү?		/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/
3.	<b>Тасалдах:</b> Шээс тасалдаж дахин шээдэг үү?		/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/
4.	<b>Яаралтай:</b> Шээсээ суллах яаралтай шаардлага хир ойрхон гардаг вэ?		/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/
5.	<b>Шээсний эрч</b> суларсан мэт санагдаж байна уу?		/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/
6.	<b>Дүлэлт:</b> Шээх үедээ дүлдэг үү?		/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/

7.	Шөнө хэдэн удаа босож шээж байна	Үгүй	/1 оноо/	/2 оноо/	/3 оноо/	/4 оноо/	/5 оноо/
----	----------------------------------	------	----------	----------	----------	----------	----------

❖ Үнэлгээний тайлбар:

- 20-35 оноогоор үнэлсэн бол хүнд хэлбэрийн түрүү булчирхайн хам шинж
- 8-19 оноогоор үнэлсэн бол дунд зэргийн түрүү булчирхайн хам шинж.
- 1-7 оноогоор үнэлсэн бол хөнгөн хэлбэрийн түрүү булчирхайн хам шинж тус тус илэрсэн гэж дүгнэнэ.

**3. Эрэгтэйн насжилтын шинж тэмдгийн асуумж**

Шинж тэмдэгүүд		Үгүй	Сул	Дунд зэрэг	Их	Маш их
Оноо		1	2	3	4	5
1.	<b>Биеийн ерөнхий байдал буурах</b> (эрүүл мэндийн байдал, өөрөө өөрийнхөө эрүүл мэндийг үнэлэх)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	<b>Үе мөч болон булчингийн өвдөлт</b> (үе мөчний өвдөлт, бүсэлхийн өвдөлт, нуруу бүхэлдээ өвдөх)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	<b>Хөлрөлт нэмэгдэх</b> (гэнэт хөлрөх, ачааллаас үл хамааран үе үе халуу оргих)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4.	<b>Нойрны асуудлууд</b> (нойр хулжих, эрт сэрэх, ядрах, нойр муудах, нойргүйдэх)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5.	<b>Нойрны хэрэгцээ ихсэх, байнга ядарсан мэдрэмж төрөх</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.	<b>Цочромтгой болох</b> ууртай болох, яльгүй зүйлд цухалдах)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7.	<b>Мэдрэлийн ядаргаа</b> (ачаалал, зовууртай байх, самгардах, тавгүйтэх)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8.	<b>Түгшүүр</b> (сэтгэл түгших, санаа зовних, заримдаа сааталд орох )	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9.	<b>Биеийн тамир тэнхээ муудах, амьдралын эрч хүч доройтох</b> (ерөнхий ажиллах чадвар, идэвх сулрах, ач холбогдол багатай үйл ажиллагаанд идэвх буурах, өөрийн үнэлэмж багасах, хийсэн юмандаа	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



	сэтгэл хангалуун бус байх, ханасан мэдрэмж төрөх, хүчлүүлж байж хийх)					
10.	<b>Булчингийн хүч сулрах</b> (гар хөл болон бүх бие сулрах)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11.	<b>Сэтгэл гутрал</b> (дарамттай юм шиг санагдах, гуниг төрөх, уйламхай болох, жолоодлого алдагдах, ааш зан тогтворгүйтэх, хэнд ч хэрэггүй мэт санагдах)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12.	<b>Амьдралын оргил үе өнгөрсөн мэт санагдах</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
13.	<b>Шатаж дууссан, хоосорсон мэт санагдах</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
14.	<b>Сахал үсний ургалт багасах</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
15.	<b>Бэлгийн харьцааны чадамж ба давтамж цөөрөх</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
16.	<b>Өглөөний хөвчрөлтийн тоо цөөрөх</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
17.	<b>Бэлгийн дур хүсэл буурах</b> (бэлгийн ханамж буурах, хавьтах дур хүсэл буурах)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<b>Танд өөр ямар нэг мэдэгдэхүйц шинж тэмдэг ажиглагдаж байна уу?</b>			<b>Тийм.....</b> <input type="checkbox"/>		<b>Үгүй.....</b> <input type="checkbox"/>	
Хэрэв “Тийм” бол, тайлбарлаж бичнэ үү: _____ _____ _____						

❖ Эрэгтэйн насжилтын шинж тэмдгийн хэмжүүрийг дүгнэх:

№	Асуултууд	Хэвийн	Хөнгөн	Дунд	Хүнд
1.	Нийт оноо	<26	27-36	37-49	50<
2.	Сэтгэл зүйн	<5	6-8	9-12	13-18
3.	Бие махбодын	<8	9-12	13-18	19<
4.	Бэлгийн үйл ажиллагаа	<5	6-7	8-10	11<

#### 4. Архи, тамхи, сэтгэц нөлөөт бодисын хамаарлыг илрүүлэх асуумж

##### 4.1 Тамхины хамаарлыг илрүүлэх Фагестромын тест

№	Асуулт	Хариулт	Оноо
1.	Өглөө сэрээд хэдэн минутын дараа анхны тамхи татдаг вэ?	5 минутын дотор	3
		6-30 минутанд	2
		31-60 минут	1
2.	Тамхи татахыг хориглосон газруудад тамхи татахгүй байх хэцүү байдаг уу?	Тийм	1
		Үгүй	0
3.	Хэдийд тамхи татахгүй байхад танд хамгийн хэцүү байдаг вэ?	Өглөөний анхны тамхийг	1
		Бусад үеийн тамхийг	0
4.	Өдөрт хэдэн тамхи татдаг вэ?	10 ба түүнээс дээш	0
		11-20	1
		21-30	2
		31 ба түүнээс их	3
5.	Та үдээс өмнө цагуудад бусад цагуудыг бодвол олон тамхи татдаг уу?	Үгүй	0
		Тийм	1
6.	Хэрэв та өвчтэй юм уу өдөржингөө орондоо байвал тамхи татдаг уу?	Үгүй	1
		Тийм	0

❖ Тамхины хамаарлыг илрүүлэх Фагестромын тестийн үнэлгээний дүгнэлт:

№	Үнэлгээний тайлбар	Оноо
1.	Маш бага хамааралтай	0-3
2.	Бага хамааралтай	4-5
3.	Дунд зэргийн хамааралтай	6-7
4.	Хамаарлын хэмжээ их	8-9
5.	Маш өндөр хамааралтай	10

##### 4.2 Архи болон сэтгэц нөлөөт бодисын хамаарлыг илрүүлэх ASSIST (Alcohol, Smoking and Substance Involvement Screening Test) – ийн асуумж

<b>Асуулт 1.</b> Та амьдралдаа дараах мансууруулах бодисоос эмнэлгийн бус зориулалтаар хэрэглэж байсан уу?				Үгүй	Тийм
<b>Асуулт 2.</b> Та сүүлийн 3 сарын дотор өмнө дурдсан мансууруулах бодисоос (Нэг, хоёр, гурав гм) хэдэн удаа хэрэглэсэн бэ?	Огт үгүй	1-2 удаа	Сар бүр	Долоо хоног бүр	Өдөр бүр
	0	2	3	4	6
<b>Асуулт 3.</b> Танд сүүлийн 3 сард мансууруулах бодис (Нэг, хоёр, гурав гм) хэрэглэх хүчтэй дур хүсэл, эсвэл өдөөлт хэдэн удаа төрсөн бэ?	Огт үгүй	1-2 удаа	Сар бүр	Долоо хоног бүр	Өдөр бүр
	0	2	3	4	6
<b>Асуулт 4.</b> Сүүлийн 3 сард таны мансууруулах бодисын (Нэг, хоёр, гурав гм) хэрэглээнээс болж та хэдэн удаа эрүүл мэнд, нийгэм, хууль зүйн эсвэл санхүүгийн асуудалд орж байсан бэ?	Огт үгүй	1-2 удаа	Сар бүр	Долоо хоног бүр	Өдөр бүр
	0	2	3	4	6
<b>Асуулт 5.</b> Сүүлийн 3 сард мансууруулах бодис (Нэг, хоёр, гурав гм) хэрэглэснээс болж та хэдэн удаа өдөр тутмын үйл ажиллагаа явуулах чадваргүй болж байсан бэ?	Огт үгүй	1-2 удаа	Сар бүр	Долоо хоног бүр	Өдөр бүр
	0	2	3	4	6
Хэрэглэж байсан бодис бүр дээр Асуулт 6 – аас Асуулт 7 дугаар асуултыг асууна (Асуулт 1 дээр хариулсан бодис бүр дээр)					
<b>Асуулт 6.</b> Таны найз, гэр бүлийнхэн эсвэл хэн нэгэн таны хэрэглээний талаар санаа зовж байгаага танд илэрхийлж байсан уу?	Огт үгүй	1-2 удаа	Сар бүр	Долоо хоног бүр	Өдөр бүр
	0	2	3	4	6
Хэрэглэж байсан бодис бүр дээр Асуулт 6 – аас Асуулт 7 дугаар асуултыг асууна (Асуулт 1 дээр хариулсан бодис бүр дээр)					
<b>Асуулт 7.</b> Та урьд өмнө нь мансууруулах бодисын хэрэглээгээ (Нэг, хоёр, гурав гэх мэт) хянах, багасгах эсвэл зогсоох оролдлого хийж, тэр нь бүтэлгүйтэж байсан уу?	Огт үгүй	1-2 удаа	Сар бүр	Долоо хоног бүр	Өдөр бүр
	0	2	3	4	6
<b>Асуулт 8.</b> Та ямар нэг мансууруулах бодисыг эмнэлгийн бус зориулалтаар тарьж хэрэглэж байсан уу?	Огт үгүй		Тийм, сүүлийн 3 сард		Тийм, гэхдээ сүүлийн 3 сард биш
Та тохирох хайрцагт (+) тэмдэг тавина уу					

❖ Архи болон сэтгэц нөлөөт бодисын хамаарлыг илрүүлэх ASSIST (Alcohol, Smoking and Substance Involvement Screening Test)-ийн онооны тайлбар:

№	Архи	Бусад мансууруулах бодис	Эрсдэлийн түвшин	Тусламж, үйлчилгээ
1.	0-10	0-3	Бага эрсдэлтэй	- Ерөнхий эрүүл мэндийн зөвлөгөө өгөх
2.	11-26	4-26	Дундаж эрсдэлтэй	- Богино хугацааны эрчимтэй зөвлөгөө өгөх - Гэртээ харихад нь мансууруулах бодисуудын тухай мэдээлэл, санамж өгөх
3.	27+	27+	Өндөр эрсдэлтэй	- Богино хугацааны эрчимтэй зөвлөгөө өгөх - Гэртээ харихад нь мансууруулах бодисуудын тухай мэдээлэл, санамж өгөх - Нарийн мэргэжлийн эмчилгээ, оношилгоонд явуулах

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дугаар сарын 01 -ны өдрийн 44 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН КАБИНЕТЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

1. Эрэгтэйчүүдийн кабинетэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл

№	Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	Шаардлагатай тоо хэмжээ
1.	Үзлэгийн ор	1-ээс доошгүй
2.	Хажуугийн гэрэл	1-ээс доошгүй
3.	Боолтын багажны иж бүрдэл	1-ээс доошгүй ком
4.	Багаж тавих ширээ	2-оос доошгүй
5.	Эмнэлгийн хэрэгслийн шүүгээ	2-оос доошгүй
6.	Сорох төхөөрөмж /цахилгаан /	1-ээс доошгүй
7.	Сандал /эргэдэг, төмөр/	3-аас доошгүй
8.	Нил ягаан туяаны гэрэл суурин	2-оос доошгүй
9.	Мэс заслын ор /байрлал тохируулагч бүхий/	1-ээс доошгүй
10.	Мэс заслын гэрэл /хажуугийн гэрэл бүхий 2 хэсэгтэй/	1-ээс доошгүй
11.	Коагулятор	1-ээс доошгүй
12.	Багаж угаах, ариутгах зориулалтын сав	Тухайн хэрэгцээнд
13.	ЭХО аппарат /Хэвлийн болон шугаман, шулуун гэдэсний датчиктай/	1-ээс доошгүй
14.	Үлдэгдэл шээс хэмжигч аппарат /Шаардлагатай бол/	1-ээс доошгүй
15.	Давсагт гуурс тавих троакарын иж бүрдэл /Ариун/	1-ээс доошгүй ком
16.	Хөргөгч	1-ээс доошгүй
17.	Орхиодометр /Төмсөг хэмжигч/	1-ээс доошгүй
18.	Телевиз бүхий тусгаарлагдсан хэсэг	1-ээс доошгүй

## 2. Эрэгтэйчүүдийн кабинетад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл

№	Эм, эмнэлгийн хэрэгсэл	Савлалтын хэмжээ
1.	Фoley катетер /Ариун/	12, 14, 16, 18, 20, 22, 24 Fr
2.	Шээдэг сүв тэлэгч	12, 14, 16, 18, 20, 22, 24 Fr
3.	Ариун бээлий /Ариун/	6, 6.5, 7, 7.5, 8
4.	Ариун шарик /Ариун/	50 гр, 100 гр
5.	Ариун самбаа	32s/30x28 7mx14cm
6.	Үзлэгийн бээлий	6, 6.5, 7, 7.5, 8
7.	Тамедин 2.5%, 7.5%	100мл, 250мл
8.	Лидокайн 0.5%, 2%	2 мл
9.	Спирт 76%	100мл, 250мл
10.	Спирт 96%	100мл, 250мл
11.	Шээдэг сүвний зориулалтын тос	10мл, 20мл
12.	ЭХО гель	100мл, 250мл
13.	Шприц	3гр, 5гр, 10гр, 20 гр
14.	Соруулгын шприц	50гр, 60гр
15.	Яаралтай тусламжийн эм хэрэгсэл	Иж бүрдэл /1-ээс доошгүй ком/
16.	Физиологийн уусмал 09%	100мл, 250мл, 500мл
17.	Утас Silk /Ариун/	1-0, 2-0, 3-0,
18.	Утас Vicryl /Ариун/	1-0, 2-0, 3-0, 4-0
19.	Хутганы ир /Ариун/	№10 болон №12
20.	Давсагт тавих цистостомийн гуурсны иж бүрдэл /Ариун/	10ch, 12ch, 14ch
21.	Бөөрөнд тавих нефростомийн гуурсны иж бүрдэл /Ариун/	8ch, 10ch
22.	Биопси авах иж бүрдэл /Хагас автомат/	18G 20cm